Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Бага боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Сүхбат Долгормаа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. 1.1. Багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 1 | Ментор багш нарыг бэлтгэж, Ментор хөтөлбөр хэрэгжүүлэх. | Ментор багш нарын тоо | Бэлтгэгдсэн ментор багш-33 | 21 | 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжүүлж буй Менторшип хөтөлбөрийн үргэлжлэл 25 Ментор багш бэлтгэх хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах бэлтгэл хангах, зураглал боловсруулахад хамтран ажиллаж байна. Ментор багш бэлтгэх хөтөлбөр нь 9 дүгээр сард боловсруулж дуусган багш бэлтгэх сургалт 10 дугаар сард хийхээр төлөвлөсөн ба гүйцэтгэл 2025 оны 2 дугаар хагаст үргэжилнэ. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |
| 2 | Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн | Дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын | 50% | Багшийн хөгжлийн тухай хууль, Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны бодлого, Багшийн гурван | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах. | ажиллагааны тоо, батлагдсан удирдамж, тайлангийн гүйцэтгэлийн хувь | байгууллагын 950 захирал, эрхлэгч нарт сургалт зохион байгуулсан | | тулгуурт бодлого зэрэг баримт бичгүүдийг үндэслэл болгож Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг хөгжүүлэх, төвийн үйл ажиллагаанд тулгуурлан, багш нарыг ажлын байранд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН БАГШИЙН ХӨГЖИЛ ХАРИУЦСАН СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ”-ыг 2025 оны 2 дугаар сараас 05 дугаар саруудад зохион байгуулсан. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 3 | Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих үндсэн сургалт зохион байгуулах. | үндсэн сургалтад хамрагдсан багшийн тоо | Үндсэн сургалтад хамрагдсан нийт багш -1435 | 1000 | Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын бэлтгэл ажил хангах, сургалтад хамрагдах 5, 10, 15, 20 жилийн багш нарын нэрсийг шүүх, тулгах, агуулгын боловсруулалт хийж ажилласан. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтаар 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 4 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Завхан, Увс, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Архангай, Дорнод аймгуудад сургагч багшаар ажиллан тус бүр 45-50 оролцогч бүхий анги чиглүүлэн 4 дүгээр сарын 3,4 нд Дорнод аймагт, Нийслэлийн БЗД 4 дүгээр сарын 7,8,СБД-т 4 дүгээр сарын 9,10 нд үндсэн сургалтын сургагч багшаар ажилласан. 1. Эргэцүүлэлд суурилсан багшийн хөгжил, 2. Багшийн цахим ур чадвар, 3. Хичээлийн судалгааны арга зүй гэсэн агуулгыг хөтөлбөрийн дагуу амжилттай хэрэгжүүллээ. | | |
| 4 | Багшийн хөгжлийг дэмжих платформд суурилсан цахим сургалтын сан бүрдүүлэхэд хамтарч ажиллах | Платформд байршуулсан шаардлага хангасан цахим сургалтын тоо | 1-р ангитай ажиллах-1 ТДХ-1 | 3 | Багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газраас сургалтын байгууллагын багш, удирдах ажилтан өөрсдийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломж бий болгох зорилт тавин ажиллаж байна.Багшийн хөгжлийг дэмжих Bagsh.edu.mn платформд суурилан суралцах боломжтой болж байна.Боловсролын ерөнхий газраас 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулсан модуль сургалтын үр дүнгийн судалгаа, мониторингоос багш нараас хамгийн өндөр үнэлгээ авсан 12 модулийг сонгож, боловсруулсан багтай гэрээ байгуулан БЕГ-ын өмчид | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авсан.Манай байгууллага гэрээний дагуу тус 12 модулийг ашиглан сургалт зохион байгуулах эрхтэй. Багшийн хөгжлийн Bagsh.edu.mn платформд 12 модулийг байршуулсан бөгөөд багш нар сонголтоороо үнэ төлбөргүй судалж, амжилттай төгсвөл батламж авах боломжийг бүрдүүллээ. Хавсралт: 1 файл | | |
| 5 | Багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх. | Хөтөлбөрийн батлагдсан удирдамж, төлөвлөгөө, оролцогчдын тоо | Сургалтын байгууллага-2, багш -10 | 10 | 2025 оны 2 дугаар хагаст гүйцэтгэх ажил. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 10% |
| 6 | Ерөнхий боловсрол, сургалтын байгууллагын багшид мэргэжлийн “Зөвлөх” зэрэг олгох дүгнэлт гаргах. | Дүгнэлт гаргасан материалын гүйцэтгэлийн хувь | Дүгнэлт гаргасан материал 40 | 50% | ЕБС-ийн багш нарын Зөвлөх мэргэшлийн зэргийн материал одоогоор ирээгүй байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |
| 7 | Сургалтын байгууллагын “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, үндэсний | Зөвлөн тусалсан МХБ-ийн тоо, үр дүнтэй МХБ-ийн сайн туршлага | БЕГ-аас баталсан аргачлал, чиглэл, тайлант өдөрлөг зохион байгуулах удирдамж, сургалтын | 4 | 1. БАБХГ-ын мэргэжлийн хөгжлийн бүлгийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллалаа. 2. Ерөнхий боловсролын 156 сургуулиас мэргэжлийн багшийн бүлгийн үйл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулж, үр дүнтэй МХБ-ийн сан бүрдүүлэх. | | байгууллагын МХБ-үүд ажиллах удирдамж чиглэл | | ажиллагааны үр дүнгээр асуулга судалгаа авч үр дүнг боловсруулахад хамтран ажиллаж байна. Судалгааны үр дүнг сургалтын байгууллагын "Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-ийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, үндэсний хэмжээнд тайлант өдөрлөг зохион байгуулах, МХБ-ийн сайн туршлагын сан бүрдүүлэхэд чиглэж бэлтгэл хангаж байна. Тус судалгаанаас багшийн хөгжлийн төлөвлөгөөний 60 орчим хувийг мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагаа эзэлж байна. Сургуульд дунджаар 5 мэргэжлийн багш нарын бүлэг ажиллаж байна. Мэргэжлийн багш нарын бүлгээр бүх багш нар хамрагддаг болсон зэргийг илрүүлсэн бэлтгэл хангахад суурь тавигдлаа.<br>Хавсралт: 2 файл | 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 8 | Хамтын ажиллагаа, санамж бичгийн хүрээнд гадаад улсын Боловсролын газартай туршлага солилцох үйл ажиллагаа зохион байгуулах. | Туршлага солилцсон албан хаагчийн тоо, гүйцэтгэлийн хувь | 6 албан хаагч хамрагдсан. | 100% | 2025 оны 2 дугаар хагас жилд энэ үйл ажиллагаа хийгдэх болно | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 9 | ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтаас бусад олон | Сургалт, үйл ажиллагааны батлагдсан хөтөлбөр, | Сургалт-8, оролцогч-1211 | 3 | БГ-ын мэргэжилтэн, ЕБС-ийн Багш, удирдах ажилтны цахим платформд байршуулах материалуудад эксперт хийж | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талт (эрдэм шинжилгээний болон онол практикийн бага хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, түншлэл, хамтын үйл ажиллагаа) ажлыг зохион байгуулах. | удирдамж, тайлан, оролцогчдын тоо | | | ажилласан."Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих" төслийн тэгш хамруулан сургах боловсролын тайлан хэлэлцүүлэгт оролцсон.Үндсэн сургалтад хамрагдсан бага боловсролын судлагдхууны багш нарын цахим талбарт төлөвлөгөө, даалгавар,сорил боловсруулан, байршуулж оролцогчдын байршуулсан даалгаварт хяналт үнэлгээ хийж ажиллалаа. Мөн Үндсэн сургалтад сургагч багшаар ажилласан багш нарын санхүүгийн баримт бичгийг хураан авч нэгтгэсэн. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 10 | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах. | Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө оролцогчдын тоо, хувь | Үндэсний хэмжээнд 21 сургагч багш бэлтгэгдсэн. | 100% | Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 12-14 -ний өдөр зохион байгуулах ажлын хэсэгт хамтран ажиллаж, сургалтад хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, онол арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, улмаар сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвийг хөгжүүлэх, төвийн үйл ажиллагаанд тулгуурлан, багш нарыг ажлын байранд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Завхан, Увс аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг 2025 оны 4 дүгээр сарын 23- 29-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 11 | Орон нутгийн байгууллагын бага боловсролын судлагдахуун хариуцсан арга зүйч нарыг чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах. | Сургалтын батлагдсан хөтөлбөр, удирдамж, тайлан хамрагдсан хүний тоо, хувь | Сургалт-2, оролцогч-128 | 50% | Бага боловсролын судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, хэрэгцээг илрүүлэх асуулга боловсруулах, БАБХГ-ын дарга мэргэжилтнүүдтэй хэлэлцэж хугацааг товлох зэрэг ажлын хүрээнд бэлтгэл хангаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 70% |
| 3.1. Нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдөн ажиллах | | | | | | | |
| 12 | Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | Биелэлт /хувь/ | 100% | 100% | Боловсролын сайдын 2024 оны “Ерөнхий боловсролын сургуульд багшийн туслах ажиллуулах тухай” А/63 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор БЕГ-ын дэйж хуудсанд мэдээлэл бэлтгэж оруулсан. Ерөнхий боловсролын сургуульд ажиллах "Багшийн туслах"-ын тайлан нэгтгэж гаргасан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж болгон хадгалуулах | Архивт хүлээлгэн өгөх баримтын тоо | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу боловсруулсан шаардлагатай баримт бичгийг архивт өгөх | 1 | Өөрийн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үндсэн сургалтын материалуудыг хүлээлгэн өгсөн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 14 | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх | Биелэлт /хувь/ | 100% | 100% | Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг ажилдаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах | Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах дотоодын сургалтуудад хамрагдах ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | 1. 2-р сарын 5-аас 2-р сарын 7-ны өдрүүдэд Олон улсанд хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх Мозайк үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж сертификат авсан. Боловсролын сайдын 2025.01.22-ны өдрийн А/25 дугаар тушаал, Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, Хүүхдийн цэцэрлэг, ерөнхний боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам зэргийг уншиж судлан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулга боловсруулах, сургалт чиглүүлэхдээ баримталж ажилласан. 4.ЕБС-ийн Багшийн хөгжил хариуцсан сургалтын менежерүүдийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чадавхжуулах сургалтад хамрагдсан. БЕГ-ын хүний нөөцийг чадавхижуулах ээлжит сургалт болох "Нийгмийн даатгалын шинэчлэл" сургалтад 2025 оны 05 сарын 19-ны өдөр хамрагдаж нэмэлт өөрчлөлт шинэчлэл, зорилго зориулалт, аргачлалын талаар мэдлэг мэдээлэлтэй боллоо.Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжсэн "Ковид-19-ийн дараах боловсролын сэргэлтийг дэмжих төсөл"-ийн хүрээнд зохион байгуулагдсан “Сургуульд суурилсан менежмент” сэдэвт сургалтыг амжилттай дүүргэж, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батламжаа авсан. Энэхүү сургалтад хамрагдсанаар “Сургуульд суурилсан менежмент”-ийн талаар онолын мэдлэг, практик ур чадварыг эзэмшиж, удирдах арга барилдаа шинэлэг, үр дүнтэй өөрчлөлтүүдийг нэвтрүүлэх хэрэгжүүлэхэд илүү мэргэшсэн. Хавсралт: 1 файл | | |
| 2 | Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах | Судалсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судалсан ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Боловсролын сайдын 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн "Журам батлах тухай" А/25 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар батлагдсан хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, үйл ажиллагааны журамын танилцуулга, хүлээлгэн өгөх үйл ажиллагаанд оролцож, уншиж судлан, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын төсөл боловсруулах, бэлтгэл хангах, зохион байгуулах ажилд тусган хэрэгжүүллээ. Цаашид МХБ-ийн болон дадлагажуулах үйл ажиллагааны хөтөлбөр, жишиг загварг боловсруулах зэргээр хамтран ажиллаж байна."И Эс Эйч сургалтын төвийн Төрийн албаны ерөнхий шалгалтад бэлтгэх 21 хоногийн онлайн сургалтад 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс хамрагдан суралцсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Бага боловсролын багшийн хөгжил хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Сүхбат Долгормаа /................................................./
Огноо: .........................